



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/120

Хэрлэн сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.1.1, 2.2.1.1.2 заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд элсэлтийн шалгалтын үр дүнг сайжруулах зорилготой багш суралцагчдыг чадавхжуулах танхимын болон цахим сургалтад шаардагдах "Хүртээмжтэй боловсролын төлөөх багш нарын холбоо"-ны ажил гүйцэтгэх гэрээний 19,000,000 (арван есөн сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг санхүүжүүлэх зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, боловсролын байгууллагын чанар хүртээмжийг сайжруулж, дэвшилтэт технологи ашиглан цахим болон танхимын сургалтыг үр дүнтэй зохион байгуулахыг Боловсролын газрын дарга (С.Мөнхцэцэг)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орон тооны зөвлөх (Г.Тайванжаргал)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



ДАЮУРБУНЬ

